



МОНГОЛБАНК
МОНГОЛ УЛСЫН ТӨВ БАНК

ИРГЭДИЙН ИНФЛЯЦЫН ХҮЛЭЭЛТИЙН ТҮҮВЭР СУДАЛГАА

2025 оны IV улирал

2026 оны 2 дугаар сар




I. ХУРААНГУЙ

Улсын инфляцыг 2025 оны III улирлаас эхлэн бодлогын шийдвэрт ашиглаж эхэлсэнтэй уялдуулж, энэ удаагийн түүвэр судалгаанаас эхлэн хамрах хүрээг улсын хэмжээнд болгон өргөжүүллээ. Улмаар тус түүвэр судалгааны мэдээллийг 2026 оны 2 дугаар сарын 6-24-ны өдрүүдэд цуглуулж, улсын хэмжээнд иргэдийн байршил, хүйс, насны бүлэг, өрхийн орлогын бүтцийг төлөөлөх нийт 1,760 иргэнийг хамрууллаа. Судалгааны голлох үр дүнг дараах байдлаар нэгтгэн танилцуулж байна.

- Судалгаанд 26-55 насны дээд боловсролтой, эмэгтэй иргэд түлхүү оролцлоо.
- Түүвэр судалгаанд хамрагдсан иргэдийн хариултад үндэслэн тооцсон хүлээгдэж буй инфляцаас үзэхэд ирэх 3 сард (2026 оны I улирлын эцэст) инфляц одоогийн түвшнээс бага зэрэг буурах, харин ирэх 12 сард (2026 оны жилийн эцэст) бага зэрэг нэмэгдэх хүлээлттэй байна. Ийнхүү инфляцын хүлээлт зорилтот түвшний дээд интервалын орчимд хадгалагдаж, богино хугацаанд харьцангуй тогтворжсон төлөв ажиглагдлаа (Зураг 1).
- Өрхийн орлогын хүлээлт бага зэрэг өсөж, зардлын хүлээлт өмнөх улирлаас бага зэрэг буурснаар өрхийн хуримтлалын хүлээлт бага зэрэг сайжирлаа.
- Иргэдийн дунд ажил эрхлэлт өөрчлөлтгүй байх хүлээлт давамгайлж байна. Мөн эдийн засаг удаашрах, төгрөгийн ханш үргэлжлэн сулрах хүлээлттэй гарлаа.
- Ирэх улиралд зээлийн хүү өсөх хүлээлттэй гарлаа.

Зураг 1. Инфляцын хүлээлт




Эх сурвалж: Иргэдийн инфляцын хүлээлтийн түүвэр судалгаа

II. ИНФЛЯЦЫН ХҮЛЭЭЛТ


Түүвэр судалгаанд оролцсон иргэдийн чанарын хариултад үндэслэн өнгөрсөн хугацааны үнийн өсөлтийн мэдрэмжийн индексийг тооцоход өнгөрсөн 3 болон 12 сарын хугацааны хувьд өмнөх улирлын судалгааны үр дүнгээс бага зэрэг буурсан хэдий ч “инфляц өссөн” мужид хэвээр хадгалагдлаа (Зураг 2).

Мөн ирэх хугацааны инфляцын хүлээлтийн индексийг тооцоход ирэх улирлын болон ирэх 1 жилийн хүлээлтийн индексийн утгууд өмнөх улирлаас бага зэргийн буурсан бөгөөд индексийн утга тус бүр “инфляц өснө” мужид хадгалагдсан хэдий ч сүүлийн 3 улирал дараалан буурах хандлагатай байв (Зураг 3).

Зураг 2. Инфляцын мэдрэмжийн индекс¹



Зураг 3. Инфляцын хүлээлтийн индекс




Эх сурвалж: Иргэдийн инфляцын хүлээлтийн түүвэр судалгаа

Түүнчлэн ирэх хугацааны хүлээлтийн талаарх иргэдийн тоон хариултад үндэслэн инфляцын дундаж утгыг тооцоход 2026 оны I улирлын хүлээлт өмнөх улирлаас 2.0 нэгж хувиар буурч **7.3%**, 2026 оны IV улирлын хүлээлт өмнөх улирлаас 1.4 нэгж хувиар буурч **8.6%**-тай тус тус гарлаа. Харин инфляцын хүлээлтийн тоон хариултаас медиан² утгыг тооцоход 2026 оны I улирлын хүлээлт өмнөх улирлаас 2.6 нэгж хувиар буурч **7.5%**, 2026 оны IV улирлын хүлээлт өмнөх улирлаас 2.2 нэгж хувиар буурч **8.7%**-тай гарлаа (Зураг 4, Зураг 5). Өөрөөр хэлбэл, 2024 оны II улирлаас хойш тасралтгүй нэмэгдээд байсан инфляцын хүлээлтийн утга сүүлийн 3 улирал дараалан бага зэрэг буурч, инфляцын зорилтот түвшний дээд интервалын орчимд хадгалагдаж, үнийн хүлээлт харьцангуй тогтворжоод байна.


¹ Бараа, үйлчилгээний үнийн ерөнхий түвшин өнгөрсөн хугацаатай харьцуулахад хэрхэн өөрчлөгдсөн талаар мэдрэмжийг асууж, “маш ихээр өссөн”, “нэлээдгүй өссөн”, “аажмаар өссөн”, “хэвэндээ” болон “буурсан” гэсэн хариултуудыг [3;-1] утгаар нормчилж чиглэлийн индексийг тооцсон болно.

² Тоон асуулгын хариултаас [Nicholas J. Cox \(2009\)](#)-ийн боловсруулсан “Хагас тархалтын функц” болон “Симметрик шугаман интерполяци медиан” аргачлалыг ашиглан тоон хүлээлтийн тархалт болон медиан утгыг тооцсон болно.

Зураг 4. Тоон хариултаас тооцсон инфляцын хүлээлтийн медиан болон дундаж утга, ирэх 3 сар



Зураг 5. Тоон хариултаас тооцсон инфляцын хүлээлтийн медиан болон дундаж утга, ирэх 12 сар




Эх сурвалж: Иргэдийн инфляцын хүлээлтийн түүвэр судалгаа


Ирэх 3 сарын инфляцын хүлээлтийн тоон хариултын тархалтаас харахад өмнөх улиралд 11% орчимд хамгийн өндөр давтамжтай, илүү өргөн тархсан хэлбэртэй байсан бол тайлант улиралд 7%-9% орчимд төвлөрч, зүүн тийш шилжсэнээр хүлээлтийн утга бага зэрэг буурч, хүлээлтийн тархалт тогтворжсон хандлага ажиглагдлаа (Зураг 6).

Мөн ирэх 12 сарын инфляцын хүлээлтийн тархалтын хувьд тайлант улиралд 9% орчимд төвлөрсөн, ойролцоогоор нормал хэлбэртэй боловч бага зэрэг баруун хэлбийлттэй байна. Өмнөх улирлын тархалттай харьцуулахад голч утга зүүн тийш шилжсэн харьцангуй нягтарсан бүтэцтэй байна (Зураг 7). Өөрөөр хэлбэл, инфляцын хүлээлт харьцангуй тогтворжиж, тодорхой бус байдал буурсан гэж хэлж болохоор байна.

Зураг 6. Инфляцын хүлээлтийн тоон хариултын тархалт, ирэх 3 сар




Зураг 7. Инфляцын хүлээлтийн тоон хариултын тархалт, ирэх 12 сар



Эх сурвалж: Иргэдийн инфляцын хүлээлтийн түүвэр судалгаа

Судалгаанд оролцогчдын 41% нь 2026 оны I улиралд инфляц “Өнөөгийн түвшнээс илүү өснө” гэсэн хүлээлттэй байна. Өмнөх улирлын үр дүнтэй харьцуулахад 15 нэгж хувиар буурсан буюу инфляц одоогийн түвшинд эсвэл бага байх хүлээлтийн утгуудын эзлэх хувь нэмэгдсэн нь судалгаанд оролцогчид илүү бодит, тогтвортой өсөлтийг төсөөлж байна. Гэсэн хэдий ч нийт оролцогчдын 77% үнэ нэмэгдэх хүлээлттэй байгаа нь инфляцын дарамт хэвээр байгааг илтгэнэ (Зураг 8).


Зураг 8. Инфляцын хүлээлтийн чанарын хариултын тархалт, ирэх 3 сар



Эх сурвалж: Иргэдийн инфляцын хүлээлтийн түүвэр судалгаа

Харин ирэх 12 сарын үнийн хүлээлтийн хувьд инфляц илүү өсөх хүлээлт өмнөх улирлаас 4 нэгж хувиар буурсан хэдий ч судалгаанд оролцогчдын 57%-д нь инфляц илүү өсөх хүлээлт давамгайлж байна (Зураг 9). Өөрөөр хэлбэл, иргэдийн хувьд инфляц богино хугацаанд тогтворжих, саарах хүлээлттэй байгаа ч урт хугацаандаа инфляц бүрэн буурахгүй гэсэн төсөөлөлтэй байна.

Зураг 9. Инфляцын хүлээлтийн чанарын хариултын тархалт, ирэх 12 сар




Эх сурвалж: Иргэдийн инфляцын хүлээлтийн түүвэр судалгаа


Улаанбаатар хотын иргэдийн хувьд 2026 оны I улиралд **7.9%**, 2026 оны жилийн эцэст инфляц **9.1%** байх хүлээлттэй байна. Харин орон нутгийн иргэдийн хувьд харгалзан **6.9%**, **8.2%** байх хүлээлттэй гарлаа. Инфляцын хүлээлтийн дундаж утгын зөрүүг бүс нутгийн түвшинд харахад Улаанбаатар хотын иргэдийн хүлээлт 1 орчим нэгж хувиар илүү өндөр байна. Энэ нь байр

сууцны зардал, хүнсний бүтээгдэхүүний эх үүсвэр зэрэг хэрэглээний ялгаатай бүтцээс шалтгаалж байна (Зураг 10, Зураг 11).

Зураг 10. Инфляцын хүлээлтийн дундаж утга, байршлаар (ирэх 3 сар)




Зураг 11. Инфляцын хүлээлтийн дундаж утга, байршлаар (ирэх 12 сар)




Эх сурвалж: Иргэдийн инфляцын хүлээлтийн түүвэр судалгаа

Ирэх хугацааны тоон хүлээлтийг насны бүлгээр харьцуулахад, 2026 оны I улиралд 55-с дээш настай иргэдийн хүлээлт 1.6 нэгж хувиар буурч **7.7%**, 36-55 настай иргэдийн хүлээлт 2.2 нэгж хувиар буурч **7.4%**, 36-с доош настай иргэдийн хүлээлт 2.0 нэгж хувиар буурч **7.0%** тус тус гарлаа (Зураг 12). Харин 2026 оны IV улиралд 55-с дээш настай иргэдийн хүлээлт 0.8 нэгж хувиар буурч **9.1%**, 36-55 настай иргэдийн хүлээлт 1.5 нэгж хувиар буурч **8.7%**, 36-с доош настай иргэдийн хүлээлт 1.5 нэгж хувиар буурч **8.1%**-тай гарлаа (Зураг 13).

Зураг 12. Инфляцын хүлээлтийн дундаж утга, насны бүлгээр (ирэх 3 сар)



Зураг 13. Инфляцын хүлээлтийн дундаж утга, насны бүлгээр (ирэх 12 сар)




Эх сурвалж: Иргэдийн инфляцын хүлээлтийн түүвэр судалгаа


Ирэх хугацааны тоон хүлээлтийг орлогын ангиллаар харьцуулахад, 2026 оны I улиралд 3.0 сая төгрөгөөс дээш орлоготой болон 1.6-3.0 сая төгрөгийн орлоготой иргэдийн хүлээлт харгалзан 2.2%, 1.8%-иар буурч тус бүр **7.4%**, 1.6 сая төгрөгөөс доош орлоготой иргэдийн хүлээлт 2.1

нэгж хувиар буурч **7.1%**-тай гарлаа (Зураг 14). Харин 2026 оны IV улиралд 3.0 сая төгрөгөөс дээш орлоготой иргэдийн хүлээлт 1.5 нэгж хувиар буурч **8.8%**, 1.6-3.0 сая төгрөгийн орлоготой иргэдийн хүлээлт 1.5 нэгж хувиар буурч **8.7%**, 1.6 сая төгрөгөөс доош орлоготой иргэдийн хүлээлт 1.2 нэгж хувиар буурч **8.3%**-тай гарлаа (Зураг 15).

Зураг 14. Инфляцын хүлээлтийн дундаж утга, орлогын ангиллаар (ирэх 3 сар)



Зураг 15. Инфляцын хүлээлтийн дундаж утга, орлогын ангиллаар (ирэх 12 сар)




Эх сурвалж: Иргэдийн инфляцын хүлээлтийн түүвэр судалгаа


III. ӨРХИЙН САНХҮҮГИЙН БАЙДАЛ

Өрхийн орлогын хүлээлт өмнөх улирлын утгаас 0.03 нэгжээр өссөнөөр эерэг утгатай буюу 2026 оны I улиралд өрхийн орлого бага зэрэг өсөх хүлээлттэй гарлаа (Зураг 16). Харин өрхийн зардлын хүлээлт өмнөх улирлын утгуудтай ижил тэлэх чиглэлд байгаа бөгөөд өмнөх улирлын утгаас бага зэрэг нэмэгдээд байна (Зураг 17). Мөн бодит цалин болон өрхийн хэрэглээний өсөлт саарч байгаа нь цаашид өрхийн санхүүгийн тэнцэл хүндрэлд орж болзошгүй төлөвтэй байна.

Зураг 16. Өрхийн орлогын хүлээлт, ирэх 3 сар



Зураг 17. Өрхийн зардлын хүлээлт, ирэх 3 сар



Эх сурвалж: Иргэдийн инфляцын хүлээлтийн түүвэр судалгаа, YCX


Өрхүүдийн хадгаламжийн хүлээлт сүүлийн 7 улирал дараалан буурах чиглэлд гарлаа (Зураг 18). Харин өрхийн орлого бага зэрэг нэмэгдсэн боловч өрхийн санхүүгийн тэнцэл алдагдалтай хэвээр байна.

Иргэдийн хугацаатай хадгаламж 2025 оны эцэст 20.7 их наяд төгрөгт хүрч, өмнөх оны мөн үеэс 14.7 хувиар өсөөд байна. Нөгөө талаас, банкуудаас авсан иргэдийн хэрэглээний зээлийн үлдэгдэл 2025 оны эцсийн байдлаар 13.0 их наяд төгрөгт хүрч, өмнөх оны мөн үетэй харьцуулахад 14 орчим хувиар өсжээ. Хэрэглээний чанаргүй зээлийн эзлэх хувь өмнөх улирлаас 0.3%-иар өсөж 4.9%-тай буюу сүүлийн 6 улирал дараалан өсөж байгаа нь цаашид анхаарах үзүүлэлт болж байна.


Ирэх улиралд санхүүгийн байдлаа төлөвлөхөд хүндрэлтэй байгаа талаар судалгаанд оролцогчдын дийлэнх нь дурджээ. Энэ нь эдийн засгийн тодорхой бус байдал өндөр хэвээр байгааг илтгэнэ (Зураг 19).

Иргэдийн банкнаас авсан хэрэглээний зээлийн үлдэгдэл, түүний жигнэсэн дундаж хүү болон хугацаагаар зээлийн сарын дундаж төлбөрийг тооцоход 2025 оны эцсийн байдлаар 711.9 мянган төгрөг болж байна. Энэ нь өрхийн сарын дундаж нэрлэсэн орлогын 23.6% орчим хувьтай дүйцэж байна.

Зураг 18. Өрхийн хадгаламжийн хүлээлт, ирэх 3 сар



Зураг 19. Санхүүгийн байдлын төлөвлөлт, ирэх 3 сар




Эх сурвалж: Иргэдийн инфляцын хүлээлтийн түүвэр судалгаа, Монголбанк, ҮСХ


IV. МАКРО ГОЛЛОХ ҮЗҮҮЛЭЛТҮҮДИЙН ТАЛААРХ ИРГЭДИЙН ХҮЛЭЭЛТ

Ажил эрхлэлтийн үзүүлэлт өмнөх улирлын утгаас өсөж, ирэх улиралд ажил эрхлэлт өөрчлөлтгүй төлөвт гарлаа (Зураг 20). ҮСХ-ны мэдээгээр ажиллагчдын тооны өсөлт сүүлийн 4 улирал дараалан буурсан бол өмнөх оны мөн үеэс 2.2%-иар өссөн үзүүлэлттэй байна. Мөн эдийн засгийн өсөлтийн хүлээлтийн үзүүлэлт өмнөх улирлаас 0.08 нэгжээр өсөж -0.23 утгатай буюу эдийн засаг агших хүлээлттэй гарлаа. (Зураг 21).

Зураг 20. Ажил эрхлэлтийн хүлээлт, ирэх 3 сар



Зураг 21. Эдийн засгийн байдлын талаарх хүлээлт, ирэх 3 сар




Эх сурвалж: Иргэдийн инфляцын хүлээлтийн түүвэр судалгаа, УСХ


2025 оны эцэст 1 ам.доллар дунджаар 3,556.8 төгрөгтэй тэнцэж, өмнөх оны мөн үеэс 4.0% орчим хувиар суларсан байна. Төгрөгийн ханш ирэх улиралд үргэлжлэн суларна гэж иргэдийн дийлэнх үзэж байна (Зураг 22).

Зээлийн хүүний хувьд ирэх улиралд хүү өсөх хүлээлт иргэдийн дунд давамгайлж, өмнөх улирлын утгаас бага зэрэг өслөө (Зураг 23). Иргэдэд банкнаас олгосон хэрэглээний зээлийн жигнэсэн дундаж хүү сүүлийн 2 жилд төдийлөн өөрчлөлт ороогүй буюу 2025 оны IV улирлын байдлаар 17.6%-тай байна.

Зураг 22. Гадаад валютын ханшийн хүлээлт, ирэх 3 сар



Зураг 23. Зээлийн хүүний талаарх хүлээлт, ирэх 3 сар





Эх сурвалж: Иргэдийн инфляцын хүлээлтийн түүвэр судалгаа, Монголбанк

V. ХАВСРАЛТ

“Иргэдийн инфляцын хүлээлтийн түүвэр судалгаа”-ны мэдээллийг 2026 оны 2 дугаар сарын 6-24-ны өдрүүдэд улсын хэмжээнд, насанд хүрсэн, өмнөх улирлуудын судалгаанд оролцож байсан иргэдээс утсаар ярилцлага хийх байдлаар (708), орон нутгийн иргэдээс ярилцлага хийх байдлаар (910) болон дурын утасны дугаарлалт үүсгэж³ масс мессеж илгээх байдлаар буюу санамсаргүй түүвэрлэлтээр (142) цуглуулсан бөгөөд нийт 1,760 иргэдээс судалгааны мэдээлэл цуглууллаа. Судалгаанд оролцсон 1,760 иргэд нь эх олонлогоо бүрэн төлөөлөх чадвартай байна. Тухайлбал, судалгаанд оролцогчдын оршин суугаа хаягийг ҮСХ-оос зарласан 2024 онд Улаанбаатарт оршин суугаа хүн ам (насанд хүрсэн иргэд)-ын бүтэцтэй харьцуулахад харгалзан пропорциональ байна (Зураг 24). Баянзүрх болон Сонгинохайрхан дүүргийн иргэд Улаанбаатар хотын 44.7% бүрдүүлсэн бол орон нутгийн аймгууд тус бүр 5 орчим хувьтай хамрагдлаа (Зураг 25). Энэ удаагийн судалгаанд оролцогчдын 59% нь эмэгтэй, 41% нь эрэгтэй байна.

Зураг 24. Судалгаанд оролцогчдын оршин суугаа дүүрэг, эзлэх хувиар

Зураг 25. Судалгаанд оролцогчдын оршин суугаа аймаг, эзлэх хувиар




Эх сурвалж: Иргэдийн инфляцын хүлээлтийн түүвэр судалгаа, ҮСХ


Мөн судалгаанд оролцогчдыг насны ангиллаар харвал 26-55 насны иргэд 76.3% хувийг бүрдүүлсэн бөгөөд Улаанбаатарт оршин суугаа хүн амын насны бүлэгтэй харгалзан нийцтэй байна. Боловсролын хувьд дээд болон бүрэн дунд боловсролтой иргэд тус судалгаанд түлхүү хамрагдлаа (Зураг 26, Зураг 27).

³ “Random Digit Dailing” аргачлалыг 2025 оны 2 улирлын түүвэр судалгаанаас эхлэн ашиглаж байгаа бөгөөд энэхүү аргачлалаар түүврийн тодорхой хэсгийг бүрдүүлснээр судалгаанд оролцогч иргэдийн мэдээллийг шинэчлэх, шинэ оролцогчдыг элсүүлж, мэдээллийн санг өргөжүүлэх, насны бүлгийн залуу төлөөллүүдийн хувьд судалгаанд оролцох магадлалыг нэмэгдүүлэх, түүвэр судалгааны мэдээлэл цуглуулах цаг хугацаа, зардал хэмнэх зэрэг давуу талтай байна. Одоогоор нийт түүврийн 10 хүртэл хувийг энэхүү аргачлалаар мэдээлэл цуглуулахыг зорьж байна.

Зураг 26. Судалгаанд оролцогчдын насны ангилал




Зураг 27. Судалгаанд оролцогчдын боловсролын байдал




Эх сурвалж: Иргэдийн инфляцын хүлээлтийн түүвэр судалгаа, ҮСХ

Ажил эрхлэлтийн хувьд энэ удаагийн судалгаанд хувийн болон төрийн байгууллагад ажилладаг иргэд голлон хамрагдлаа (Зураг 28). Судалгаанд оролцогч иргэдийн өрхийн орлогын бүлэг нь ҮСХ-оос зохион байгуулдаг “Өрхийн нийгэм эдийн засгийн судалгаа”-ны өрхүүдийг мөнгөн орлогоор бүлэглэсэн хамгийн сүүлийн буюу 2025 оны IV улирлын үр дүнтэй харгалзан нийцтэй байна (Зураг 29).

Зураг 28. Судалгаанд оролцогчдын ажил эрхлэлт



Зураг 29. Судалгаанд оролцогчдын орлогын бүлэглэлт



Эх сурвалж: Иргэдийн инфляцын хүлээлтийн түүвэр судалгаа, ҮСХ